



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 1/09

Амардалай

Өмч хамгаалах байнгын зөвлөлийг  
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.7 Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.1.1 дахь заалт, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 06 тоот тогтоолоор батлагдсан Орон нутгийн өмчит хуулийн этгээд болон сумын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Г.Уугантуяа (Санхүү албаны дарга)  
Гишүүд: Л.Золжаргал (Засаг даргын орлогч дарга)  
Ч.Баярмаа (Төрийн сангийн мэргэжилтэн)  
Ц.Цэнд-Аюуш (Газрын даамал)  
Б.Ууганбаатар (Хэсгийн цагдаа)

2.Төрийн байгууллагуудын үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдалд хяналт тавьж, шинээр бүртгэлд авах, данснаас хасах, шилжүүлэх, актлах, устгах үндсэн хөрөнгийн жагсаалтыг үнэн зөв бодитоор гаргуулан холбогдох байгууллагад уламжилж ажиллахыг сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2022 оны А/32 тоот захирамжийг хүчингүйд тооцсугай.



ДАРГА

М.БАЯРСҮХ

488070145